



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 677
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БУГАТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн
талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн В.Аззаяагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа,

006021360

мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч иргэн В.Аззаяа Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч иргэн В.Аззаяагийн мөрийн хөтөлбөр (.....¹.....хуудас)-ийг хавсаргав

Хувийг: Бие даан нэр дэвшигч иргэн В.Аззаяад

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2024 ОНЫ ИТХ-Д
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ В.АЗЗАЯАГИЙН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

1.1 Боловсролын бодлого

- 1.1.1 Сургуулийн дотуур байрны болон цэцэрлэгийн хүүхдүүдийн амьдрах ая тухтай суралцах нөхцлийг бүрдүүлэх бодлогыг баримтлана.
- 1.1.2 Боксын спортыг сурталчлах бодлогыг барина.
- 1.1.3 Сумын сургууль, цэцэрлэг, биеийн тамир, спортын барилга байгууламж, хөдлөх хөрөнгийн ашиглалтад хяналт тавих бодлогыг хэрэгжүүлнэ.

1.2 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын бодлого

- 1.2.1 Иргэдийн өрхийн үйлдвэрлэл эрхлэх, зээлийн хөтөлбөрт хамруулах замаар өрхийн амжиргааны түвшинг дээшлүүлэх, сургалт хөтөлбөрт хамруулах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.3 Хөдөө аж ахуйн бодлого

- 1.3.1 Малчдыг хоршоо, нөхөрлөлийн зохион байгуулалтаар хамтран ажиллах, төрөл бүрийн үйл ажиллагаанаас орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлэх бодлогыг баримтлана
- 1.3.2 Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хангуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.3.3 Иргэдийг хүнсний ногоо, ногоон тэмжээг тариалах үйл ажиллагааг дэмжих бодлогыг хэрэгжүүлнэ

1.4 Дэд бүтэц

- 1.4.1 Цахилгаан эрчим хүчний засвар үйлчилгээ, шонг солих асуудлыг орон нутгийн бодлого шийдвэрт тусгуулах бодлогыг баримтлана.
- 1.4.2 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газрын зөрчлийг арилгах, газар ашиглалтыг сайжруулах бодлогыг дэмжинэ.

1.5 Төсөв санхүүгийн чиглэлээр

- 1.5.1 Сумын төсөв, түүний төлөвлөлт, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг олон нийтэд нээлттэй санал асуулгаар явуулах, гүйцэтгэлд олон нийт хяналт бодлогыг баримтлана.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

В.Аззаяа

В.АЗЗАЯА 99719076